

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны ... дугаар
сарын ...-ний өдөр

Дугаар

Улаанбаатар
хот

Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 7 дахь хэсэг, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 22 дугаар зүйл, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэл төлснөөр тооцох хугацаанд нийгмийн даатгалын шимтгэл төлөх журмыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2. Энэ журмыг хэрэгжүүлж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газарт даалгасугай.

3. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Монгол Улсын Засгийн газрын “Журам батлах тухай” 1994 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 212 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

4. Энэ тогтоолыг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг

Төсөл

Засгийн газрын 2022 оны ... дугаар
сарын-ны өдрийн дугаар
тогтоолын хавсралт

ДААТГУУЛАГЧИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛ ТӨЛСНӨӨР
ТООЦОХ ХУГАЦААНД НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ШИМТГЭЛ ТӨЛӨХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэ журмын зорилго нь даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэл төлснөөр тооцох хугацааны нийгмийн даатгалын шимтгэлийг ажил олгогч, даатгуулагч, нийгмийн даатгалын сан, төрөөс холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцан төлөх, бүртгэх, тайлагнахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2.Ажил олгогчоос болон даатгуулагч өөрөө хариуцан нийгмийн даатгалын шимтгэл төлсөн нийт хугацаа дээр энэ журмаар зохицуулсан нийгмийн даатгалын шимтгэл төлснөөр тооцох хугацааг нэмж, даатгуулагчид нийгмийн даатгалын хууль тогтоомжийн дагуу тэтгэвэр, тэтгэмж тогтооход энэхүү журмыг баримтална.

Хоёр.Даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэл
төлснөөр тооцох хугацаа

2.1.Даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэл төлснөөр тооцох хугацаанд дараах хугацааг хамааруулан тооцно. Үүнд:

2.1.1.хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа ажилтан, төрийн албан хаагчийн аж ахуйн нэгж, байгууллагын захиалгаар ажлаас чөлөөлөгдөж их, дээд сургууль, коллеж болон мэргэжил, мэргэшил дээшлүүлэх, олгох курст суралцсан хугацаа;

2.1.2.цэргийн жинхэнэ албыг байлдагч, түрүүчээр хаасан хугацаа;

2.1.3.хүүхдээ гурван нас хүртэл асрах чөлөөтэй байсан хугацаа;

2.1.4.хууль бусаар ажлаас зайлуулагдан мөрдөгдсөн, хилс хэргээр хорих ял эдэлсэн хугацаа;

2.1.5.хууль бусаар ажлаас халагдсан хугацаа;

2.1.6.иргэний хамгаалалтын болон бусад дайчилгааны хугацаа;

2.1.7.хөдөлмөрийн чадвар түр алдсан хугацаа;

2.1.8.жирэмсний болон амаржсаны амралттай байсан хугацаа;

2.1.9.цаатан иргэний цаа буга маллан тайгад амьдарч байгаа хугацаа;

2.1.10.хуанлийн жилд 7 сараас доошгүй хугацаагаар улирлын чанартай ажил, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагад хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа ажилтны сул зогссон хугацаа;

2.1.11.жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах эрх үүссэн нийгмийн даатгалд сайн дураар даатгуулсан эхийн хүүхдээ 3 нас хүртэл асрах хугацаа;

2.1.12.нийгмийн даатгалд албан журмаар болон сайн дураар даатгуулснаас бусад эхийн хүүхдээ 3 нас хүртэл асрах хугацаа;

2.1.13.дипломат төлөөлөгчийн газарт ажиллагчдын эхнэр/нөхрийн тодорхой ажил эрхлээгүй хугацаа;

2.1.14.цаг уурын хүнд нөхцөл бүхий улсад ажилласан хугацаа;

2.1.15.хил дээр ажиллаж байгаа гаалийн улсын байцаагчийн эхнэр, нөхрийн тодорхой ажил эрхлээгүй хугацаа;

2.1.16.төрүүлсэн болон үрчлэн авсан хүүхдийн тоогоор нэмэгдүүлэн тооцох хугацаа;

2.1.17.зэвсэгт хүчин, хилийн болон дотоодын цэрэг, тагнуул, цагдаа, онцгой байдлын алба, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад генерал, комиссар, офицер, ахмад, дэслэгч, ахлагч, түрүүч, байлдагчаар 10-аас доош жил алба хаасан хугацаа;

2.1.18.цэргийн алба хаагчийн тахир дутуугийн болон тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолгосон хугацаа;

2.1.19.цэргийн алба хаагчийн цэргийн алба хаасан хугацааг нийгмийн даатгалын шимтгэл төлснөөр өсгөн тооцох хугацаа;

2.1.20.цэргийн алба хаагчийн гадаад, дотоодын цэрэг, цагдаагийн сургуульд сонсогчоор суралцсан хугацаа;

2.1.21.улсын хил дээр алба хааж байгаа хилчний эхнэр, нөхрийн тодорхой ажил эрхлээгүй хугацаа;

2.1.22.шилжин ажиллах болсон цагдаагийн алба хаагчийн эхнэр, нөхрийн хөдөлмөр эрхлээгүй хугацаа;

2.1.23.үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас тахир дутуугийн тэтгэвэр авч байсан хугацаа.

Гурав. Даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэл төлснөөр тооцох хугацаанд шимтгэл төлөх, тооцох

3.1. Ажил олгогч дараах хугацааны нийгмийн даатгалын шимтгэлийг хариуцан нийгмийн даатгалын санд доор дурдсанаар төлнө. Үүнд:

3.1.1. энэ журмын 2.1.1-д заасан хугацааны тэтгэвэр, тэтгэмжийн даатгалын шимтгэлийг тухайн үеийн сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс ажил олгогчийн төлбөл зохих хувиар тооцон жил бүрийн сар бүр;

3.1.2. энэ журмын 2.1.2-т заасан хугацааны тэтгэвэр, тэтгэмжийн даатгалын шимтгэлийг тухайн үеийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс ажил олгогчийн төлбөл зохих хувиар тооцон цэргийн анги, байгууллага сар бүр;

3.1.3. энэ журмын 2.1.3-т заасан хугацааны тэтгэвэр, тэтгэмжийн даатгалын шимтгэлийг тухайн үеийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс ажил олгогчийн төлбөл зохих хувиар тооцон сар бүр;

3.1.4. энэ журмын 2.1.4-т заасан хугацааны нийгмийн даатгалын шимтгэлийг шүүхийн шийдвэрийг үндэслэн даатгуулагчийн хууль бусаар ажлаас зайлуулагдан мөрдөгдөх, хилс хэргээр хорих ял эдлэхийн өмнө авч байсан хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дунджаас ажил олгогч, даатгуулагчийн төлбөл зохих хувиар тооцон нэг удаа;

3.1.5. энэ журмын 2.1.5-д заасан хугацааны нийгмийн даатгалын шимтгэлийг даатгуулагчийн хууль бусаар ажлаас халагдахын өмнө авч байсан хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дунджаас ажил олгогч, даатгуулагчийн төлбөл зохих хувиар тооцон буруутай этгээд тухайн даатгуулагчийг ажилдаа эргэн орсноос хойш нэг сарын дотор нэг удаа;

3.1.6. энэ журмын 2.1.7, 2.1.8, 2.1.10-т заасан хугацааны нийгмийн даатгалын шимтгэлийг тухайн үеийн сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс ажил олгогч, даатгуулагчийн төлбөл зохих хувиар тооцон сар бүр.

3.2. Даатгуулагч дараах хугацааны нийгмийн даатгалын шимтгэлийг өөрөө хариуцан нийгмийн даатгалын санд доор дурдсанаар төлнө. Үүнд:

3.2.1. энэ журмын 2.1.11, 2.1.12-т заасан хугацааны шимтгэлийг тухайн үеийн сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс дээш орлогоос төлөх тохиолдолд зөрүү шимтгэлийг гэрээнд заасан хугацаанд;

3.3. Төр дараах хугацааны нийгмийн даатгалын шимтгэлийг хариуцан улсын төсвөөс нийгмийн даатгалын санд доор дурдсанаар төлнө. Үүнд:

3.3.1. энэ журмын 2.1.6-д заасан хугацааны тэтгэврийн, тэтгэмжийн даатгалын шимтгэлийг тухайн үеийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс ажил олгогчийн төлбөл зохих хувиар тооцон нийгмийн даатгалын санд сар бүр;

3.3.2. энэ журмын 2.1.9-д заасан хугацааны тэтгэврийн, тэтгэмжийн даатгалын шимтгэлийг тухайн үеийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс сайн дурын даатгуулагчийн төлбөл зохих хувиар тооцон нийгмийн даатгалын санд улирал бүрийн эхний сард;

3.3.3.энэ журмын 2.1.12-т заасан хугацааны тэтгэврийн, тэтгэмжийн даатгалын шимтгэлийн 50 хувийг тухайн үеийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс сайн дурын даатгуулагчийн төлбөл зохих хувиар тооцон сар бүр;

3.3.4.энэ журмын 2.1.13-д заасан хугацааны нийгмийн даатгатгалын шимтгэлийг төрийн албан хаагчийн үндсэн цалингийн дунджаас ажил олгогч, даатгуулагчийн төлбөл зохих хувиар тооцон сар бүр;

3.3.5.энэ журмын 2.1.14-д заасан хугацааны нийгмийн даатгатгалын шимтгэлийг төрийн албан хаагчийн үндсэн цалингийн дунджаас ажил олгогч, даатгуулагчийн төлбөл зохих хувиар, нэмэгдүүлэн тооцох хугацааны нийгмийн даатгатгалын шимтгэлийг тухайн үеийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс ажил олгогч, даатгуулагчийн төлбөл зохих хувиар тооцон сар бүр;

3.3.6.энэ журмын 2.1.15-д заасан хугацааны эрүүл мэндийн, тэтгэврийн даатгалын шимтгэлийг тухайн үеийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс ажил олгогч, даатгуулагчийн төлбөл зохих хувиар тооцон сар бүр;

3.3.7.энэ журмын 2.1.17-т заасан хугацааны тэтгэврийн, тэтгэмжийн даатгалын шимтгэлийг хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос ажил олгогчийн төлбөл зохих хувиар тооцон бүрэн хэмжээгээр нэг удаа;

3.3.8.энэ журмын 2.1.21, 2.1.22-д заасан хугацааны нийгмийн даатгалын шимтгэлийг тухайн үеийн сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс ажил олгогч, даатгуулагчийн төлбөл зохих хувиар тооцон сар бүр;

3.3.9.энэ журмын 2.1.18-2.1.21-д заасан хугацааны нийгмийн даатгалын шимтгэлийг Засгийн газрын 2011 оны 9 дүгээр тогтоолоор баталсан “Цэргийн тэтгэвэр авагчийн цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зөрүүг нийгмийн даатгалын санд төлөх журам”-ын дагуу.

3.4.Нийгмийн даатгалын холбогдох сангаас дараах хугацааны нийгмийн даатгалын шимтгэлийг нийгмийн даатгалын байгууллага хариуцан доор дурдсанаар төлнө. Үүнд:

3.4.1.энэ журмын 2.1.11-т заасан хугацааны тэтгэврийн, тэтгэмжийн даатгалын шимтгэлийн 50 хувийг тухайн үеийн сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс сайн дурын даатгуулагчийн төлбөл зохих хувиар тооцон тэтгэмжийн даатгалын сангаас сар бүр;

3.4.2.энэ журмын 2.1.23-д заасан хугацааны тэтгэврийн даатгалын шимтгэлийг тухайн үеийн сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс албан журмын даатгуулагчийн төлбөл зохих хувиар тооцон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас сар бүр.

Дөрөв. Нийгмийн даатгалын шимтгэл төлснөөр тооцох хугацаанд төлсөн шимтгэлийг бүртгэх, тайлагнах

4.1.Даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэл төлснөөр тооцох хугацаанд төлсөн шимтгэлийг доор дурдсаны дагуу бүртгэнэ. Үүнд:

4.1.2.энэ журмын 2.1.9-д заасан хугацааны улсын төсвөөс шилжүүлсэн шимтгэлийг нийгмийн даатгалын төв байгууллага нь холбогдох аймгийн нийгмийн даатгалын хэлтсийн зохих сангийн дансанд шилжүүлж, тухайн нийгмийн даатгалын байгууллага (байцаагч) нь төлсөн шимтгэлийг даатгуулагч бүрээр нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн санд;

4.1.3.энэ журмын 2.1.11, 2.1.12-т заасан хугацааны тэтгэмжийн даатгалын сангаас болон улсын төсвөөс шилжүүлсэн нийгмийн даатгалын шимтгэлийг нийгмийн даатгалын төв байгууллага нь холбогдох аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн зохих сангийн дансанд шилжүүлж, тухайн нийгмийн даатгалын байгууллага (байцаагч) нь төлсөн шимтгэлийг даатгуулагч бүрээр нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн санд.

4.2. Даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэл төлснөөр тооцох хугацааны шимтгэл төлөлтийн тайланг доор дурдсаны дагуу гаргана. Үүнд:

4.2.1.энэ журмын 2.1.1, 2.1.3-2.1.5, 2.1.7, 2.1.8, 2.1.10-т заасан хугацааны шимтгэл төлөлтийн тайланг ажил олгогч гарган нийгмийн даатгалын байгууллагад сар бүр;

4.2.2.энэ журмын 2.1.6-д заасан хугацааны шимтгэл төлөлтийн тайланг аймаг, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар гарган нийгмийн даатгалын байгууллагад сар бүр;

4.2.3.энэ журмын 2.1.9-д заасан хугацааны шимтгэл төлөлтийн тайланг холбогдох аймгийн нийгмийн даатгалын хэлтэс гарган нийгмийн даатгалын төв байгууллагад сар бүр;

4.2.4.энэ журмын 2.1.11, 2.1.23-д заасан хугацааны шимтгэл төлөлтийн тайланг нийгмийн даатгалын төв байгууллага улирал бүр;

4.2.5.энэ журмын 2.1.13-2.1.15, 2.1.21, 2.1.22-д заасан хугацааны шимтгэл төлөлтийн тайланг холбогдох байгууллагууд гарган нийгмийн даатгалын байгууллагад сар бүр;

4.2.6.энэ журмын 2.1.2, 2.1.17-2.1.22-д заасан хугацааны шимтгэл төлөлтийн тайланг цэргийн анги, цагдаагийн байгууллага гарган нийгмийн даатгалын байгууллагад сар бүр;

4.2.7.энэ журмын 2.1.23-д заасан хугацааны шимтгэл төлөлтийн тайланг холбогдох аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс гарган нийгмийн даатгалын төв байгууллагад сар бүр.

4.3. Энэ журмын 2.1.17-т заасан хугацааны тэтгэврийн, тэтгэмжийн даатгалын шимтгэлийг тооцох, төлөх, тайлагнах чиг үүргийг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар дараах байдлаар хэрэгжүүлнэ. Үүнд:

4.3.1. тухайн иргэний гаргасан өргөдөл, холбогдох хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын тодорхойлолтыг үндэслэн төлөх шимтгэлийн хэмжээг тодорхойлно;

4.3.2.хэрэв өндөр насны тэтгэвэр тогтоолгох хүсэлт гаргасан иргэний алба хааж байсан цэргийн анги, байгууллага татан буугдсан бол төлбөл зохих тэтгэврийн, тэтгэмжийн даатгалын шимтгэлийг тухайн үеийн сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тооцно;

4.3.3.шимтгэлийн шаардлагатай эх үүсвэрийг төлөвлөж, улсын төсвийн ангиллын "төлбөр хураамж болон бусад зардал" гэсэн зүйлд жил бүр тусгуулах арга хэмжээ авна.

4.4.Энэ журамд зааснаар төр хариуцан улсын төсвөөс төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн эх үүсвэрийг холбогдох аж ахуйн нэгж, байгууллага төлөвлөн жил бүр улсын төсөвт тусгах ажлыг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газартай хамтран гүйцэтгэнэ.

4.5.Даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэл төлснөөр тооцох хугацаанд төлөх шимтгэлийг энэ журмаар тогтоосон хугацаанд төлөөгүй тохиолдолд уг шимтгэлийг нөхөн төлөх үеийн сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, шимтгэлийн хувь хэмжээг баримтална.

Тав.Хариуцлага

5.1.Энэ журмыг зөрчсөн хуулийн этгээд, даатгуулагч (иргэн)-д холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

---oOo---